




MAPTEK™ I-Site™ Studio



3D Лазер Скандерийн програм хангамж

Хүчирхэг, Шинэлэг, Хялбар хэрэглээ

Нарийвчилсан загварчлал болон эзэлхүүний шинжилгээний өгөгдлийн хурдан боловсруулалт

Лазер сканераар бүтээлч маркшейдерийн зураглал хийх

MAPTEK I-SITE STUDIO програм нь уул уурхайн болон инженерийн үйлдвэрлэлийн лазер сканер ашиглан маркшейдерийн зураглал гаргах ажлуудыг амжилттай хийх хэрэгслүүдийг санал болгодог.

I-SITE STUDIO нь WINDOWS 64 бит үйлдлийн системийн тооцооллын давуу талуудыг ашиглан зуу зуун сканууд, сая сая цэгтэй төслүүдийг хялбархан удирдах програм юм.

Том хэмжээтэй өгөгдлийн багцыг персонал компьютер эсвэл зөөврийн компьютерт үр дүнтэй шалгах, загварчлах, зохион байгуулах боломжтой. Төслүүд, DataEngine болон сүлжээ хооронд өгөгдлийг бидний мэддэг аргуудаар дамжуулна.


I-SITE STUDIO програм нь өндөр чадвартай лазер сканерийн төхөөрөмжүүдээс авсан өгөгдлийг уламжлалт маркшейдер болон газрын зураглалтай нэгтгэдэг. Өөр эх үүсвэрүүд дэхь цэгэн үүлний өгөгдлийг боловсруулах, нийлүүлэх, загварчилах боломжтой.

Маркшейдерийн станцын өгөгдөл нь I-SITE STUDIO програмын бүртгэлийн хэрэгслүүдээр авсан дэлхийн бодит координатуудыг бусад хайлтын скануудын өгөгдөлтэй харьцуулан, нарийвчлан байрлуулах боломжтой. Глобал бүртгэлийн нэг алхамт хэрэгсэл нь хэд хэдэн сканууд болон объектуудыг хамтад нь бүртгэдэг.

I-SITE STUDIO програм нь геологийн орон зайн лазер сканерийн өгөгдлийг хамгийн үр дүнтэйгээр ашиглахад туслана. Хүчирхэг 3D график интерфейс, өнгөний болон өгөгдлийн дүрслэлтэй бөгөөд хэрэглэхэд хялбар Windows үйлдлийн системийн загвар бүхий броузертэй.

I-SITE STUDIO програм ашиглах шалтгаан:

- CAD програмын хэрэгслүүд орчны зураглалд шууд ашиглагдана.
- Хүчирхэг загварчлах хэрэгслүүд
- Зураас, хэсгүүдийг экспортлоно
- Гадаргуу, цул, дифференциал эзэлхүүний тооцоолол
- Геотехникийн тусгай хэрэгслүүд
- Шинэ тайлангийн модуль
- Шинэ геологийн хэрэгслүүд
- Уурхайн нэгдсэн маркшейдерийн ажлын урсгал
- Windows үйлдлийн системийн танил интерфейс



I-SITE ПРОГРАМ АЛИВАА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН, БҮТЭЭМЖ, УРСГАЛЫГ САЙЖРУУЛНА.

ЗАГВАРЧЛАЛ

I-SITE STUDIO програм дэд бүтцийн зураглал, загварчлалыг хялбаршуулдаг. Загваруудыг CAD wireframe8 string файл, цул гадаргуугаар хялбархан экспортлох боломжтой. ODBC ашиглан гадаад өгөгдлийн сантай холбогдох боломжтой.

- CAD зургийг string болон 3D загварчлалаар хувиргах
- 3D зайд үндэслэн гадаргууг өнгөөр ялгаж харуулах
- Газар доорх хонгил болон хоосон гадаргууг үүсгэх
- Хадгалагдаж байгаа бодит дүрсийг өргөн хүрээтэй 3D загварчлал

КОНТУР

I-SITE STUDIO програм контур болон хэсгүүдийг хурдан хувиргалт, экспорт хийнэ.

- Гадаргуугын дээд доод цэгийг автоматаар тодорхойлно.
- Дээд доод контурыг үүсгэнэ.
- Контурыг нэрлэх, өнгөөр ялгах.
- Контурыг DXF, DXB, DWG string файлаар экспортлоно.

САД ХЭРЭГСЛҮҮД

I-SITE STUDIO програм нь харагдах байдлыг дэмжих, өгөгдөл багасгах хязгаарыг тогтоох зорилгоор зураас болон олон өнцөгт гэх мэт геометрийн энгийн дүрсүүдийг ашигладаг. Хайлтын скан болон харагдацын орчны визуаль загварчлалд геометрийн дүрсийг ашиглаж болох ба засварлах явцад өөрчлөх боломжтой байдаг.

- Дизайн цэгүүд, шугам болон олон өнцөгтүүдийг зөөх, нэмэх ба устгах боломжтой
- Гадаргын зургийн тусгалыг дүрслэх, стандарт геометрийн дүрсүүдийг тааруулах, шахах
- Сонгогдсон огторгуйн дүрслэлийн өгөгдлийг дан цэг болгож эсвэл скан хийгдсэн хэсгийн хамгийн сайн таарах хавтгай болгон задлах
- Автомат ирмэг тодорхойлогчтой бүртгэгдсэн скануудын дэлгэрэнгүй 3D зургийн хязгаарын зураасыг үүсгэх.
- Загварууд болон маркшейдрийн өгөгдлийг текстээр тэмдэглэх
- SMART LINE хэрэгсэл ашиглан сканууд болон гадаргын ирмэгүүдийг дагуулан тэмдэглэх/ялгах
- LOOP WRAP хэрэгсэл ашиглан газар доорх хонгил болон хоосон/void загварчлалын хаалттай олон өнцөгт үүсгэх

ӨГӨГДЛИЙН МЕНЕЖМЕНТ


I-SITE STUDIO програм нь Windows үйлдлийн системийн хэрэглэгчийн интерфэйсийн танил загвар нь техник хангамжийн хайлт скан болон өгөгдлийн боловсруулалтыг хялбархан хийхэд туслах болно. Төслийн DataEngine руу хандах визуал хөтөч/броузер нь өгөгдлийн зохион байгуулалтыг чөлөөтэй хийх боломжоор хангана.

- Олон документтай ажиллана.
- Windows загварын сонгосон өгөгдөл хуулах, буулгах, устгах, зөөх болон үйлдэл буцаах, дахих үйлдлүүдтэй
- 3D хэмжээсээр харах цонхтой
- дэлгэцийн үзүүлэлтээр хязгаарлагдахгүй өндөр нарийвчлалтай screenshot хийнэ.
- Цонх, харагдац болон диалогийн хооронд өгөгдөл чирэх үйлдэл
- 3D PDF болон Universal 3D файлын форматаар экспорт хийнэ

УУЛ УУРХАЙН ХЭРЭГСЛҮҮД

I-SITE STUDIO програм нь олборлолтын болон маркшейдрийн програмуудад зориулсан цэгэн үүл боловсруулах багцтай. Хэрэглэгчид дэлгэрэнгүй өгөгдлийн багцуудыг ойлгоход хялбар болгон хувиргах боломжтой.


- Ил уурхайн мөргөцгийн доод болон дээд цэгийг автоматаар тодорхойлно.
- Ил уурхайн моделиудыг шинээр скан хийсэн өгөгдлөөр шинэчилнэ.
- Глобал бүртгэлийн хэрэгсэл нь тээврийн хэрэгслийн бэхэлгээтэй тохиргоо болон ашиглалтыг хялбаршуулдаг.
- Гадаргуу, цул болон дифференциал зэрэг асар том эзэлхүүний тооцооллыг хийнэ.
- Ил уурхай ба карьерийн маркшейдер хэрэгслүүд
- Хувин, шанага, болон ачааны машины эзэлхүүнүүд
- Тусгай зориулалтын геотехникийн модуль (нэмэлт лиценз шаардлагатай.)





САЛБАРТАА ТЭРГҮҮЛЭХ ДЭЛХИЙН ШИЙДЭЛ

Maptek нь уул уурхайн салбарт шинэлэг програм, техник хангамж болон үйлчилгээ үзүүлдгээрээ тэргүүлэгч билээ. 75 орны 2000 гаруй хэрэглэгч Maptek-г хэрэглэдэг. Maptek уул уурхайн технологи нь уурхайн эхлэхээс дуусах хүртэлх бүх үед хэрэглэгддэг. Манай шийдлүүд үйл ажиллагааны зардлыг бууруулж, гүйцэтгэл, бүтээмж болон ашгийг нэмэгдүүлэхэд туслах юм. Maptek нь бидний бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийсний хэрээр та бүхэнд мэргэжлийн зөвлөгөө, сургалт болон дэмжлэгийн үйлчилгээг өгч байхыг зорьдог.



Холбоо барих : +(976) 9909-5317
+(976) 7710-5105

info@itexpert.com

Албан ёсны дистрибьютор: Ай Ти Эксперт ХХК



Maptek, Vulcan, I-Site, BlastLogic, Eureka, PerfectDig and the stylised Maptek M are registered and unregistered trademarks of Maptek Pty Ltd; Maptek Computación Chile Ltda; Maptek Computación Chile Ltda, Sucursal Perú; Maptek S de RL de CV; Maptek Informática do Brasil Ltda and KRJA Systems, Inc. Registered marks are registered in one or more of the following countries: Australia, Brazil, Canada, Chile, China, Greece, India, Indonesia, Mexico, Peru, the Republic of South Africa, Russia, Spain, the United Kingdom, and the United States of America.